

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2025 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2025.12.15

Улаанбаатар хот

Нэг. Санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1,8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагын 24 нэгж болох Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 21 аймгийн орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэс, төрийн өмчит компани болох “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн нийт 24 нэгж, нэгтгэсэн 1 буюу нийт 25 нэгжийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нэгтгэхэд Улсын бүртгэлийн 23 нэгж нь “Өөрчлөлтгүй”, “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК нь “Хязгаарлалттай” дүгнэлт тус тус авсан.

Монгол Улсын ерөнхий аудиторын А/124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам” болон “Санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээ, аудит хийх шатлал болон хэлбэр” заалтын 5.3.2-г баримталж “...санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, аудит хийсэн санхүүгийн тайлангийн талаар бие даасан дүгнэлт гаргалгүй, аудитын дүнг дээд шатны байгууллагад хийсэн аудитын дүнд оруулж тайлагнах аудит” хэсгийн үндэслэн 7 хэлтэст түүврийн аудит хийгдсэн.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн 55 хувийг эзэлж байгаа Төсвийн тухай хууль зөрчсөн ангилалд багтсан алдааг жагсаахад:

- ! Орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг илүү олгосон;
- ! Цалингийн сангаас урамшуулал, тусламж олгосон;
- ! Үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдээгүй;
- ! Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг ЗГ-ын тогтоолоос илүү дүнгээр олгосон;
- ! Эдийн засгийн ангилал хооронд зориулалт бусаар зарцуулалт хийсэн;

Бусад хууль зөрчсөн ангилалд

- ! Ур чадварын нэмэгдлийг тушаалгүй олгодог;
- ! Тохируулгын тайлан хийгээгүй;
- ! Анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу;
- ! Өр, авлага үүсгэж хяналтгүй ажилласан;
- ! Тендер, сонгон шалгаруулалт зарлахгүйгээр бараа, бүтээгдхүүн худалдан авсан;
- ! Төрийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаа хоцроосон;
- ! Үндсэн хөрөнгийн бүртгэл, данснаас хасалт зөрчилтэй;

! Шилэн дансанд мэдээллийг дутуу байршуулсан;

2025 оны 01 сарын 10-ны өдрийн 7/959 дугаар албан бичгээр ТҮЦХ ТӨДХХК, 2025 оны 01 сарын 17-ны өдрийн 7/912 дугаар албан бичгээр НУБГ болон орон нутагт, 2025 оны 05 сарын 21-ны 7/7088 дугаар албан бичгээр 21 аймагт, 7/7089 дугаар албан бичгээр ТҮЦХ ТӨДХХК-д тус тус илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах хугацаатай үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг тооцон ажиллалаа.

Зөвлөмжийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн байгууллагад Төрийн аудитын байгууллагаас нийт 52 алдаа, зөрчлийн биелүүлэхдээ төлбөрийн 2 акт 100 хувь, 26 албан шаардлагын хувьд 100 хувь, 2 албан шаардлагын хувьд 98,1 хувь, 22 зөвлөмжийн биелэлтийн хувьд 100,0 хувь хугацаанд нь буюу 2025 оны 09 сарын 05-ны өдөр хүргүүлж ажилласан.

Үндэсний аудитын газарт төсвийн захирагч Ерөнхий газрын 9 заалт бүхий төлөвлөгөөг 2025 оны 03 сарын 25-ны өдрийн 1/4152 тоотой, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 17 заалт бүхий төлөвлөгөөг 2025 оны 04 сарын 29-ны өдрийн 1/5925 тоотой хүргүүлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс орон нутагт 2025 оны 05 сарын 20-ны өдрийн 7/7088, “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-нд 2025 оны 05 сарын 21-ны өдрийн 7/7089 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.

Үндэсний аудитын газарт төсвийн захирагч буюу Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 2025 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаарх явцын биелэлтийг 2025 оны 06 сарын 27-ны өдрийн 1/8471, “ТҮЦХ” ТӨДХХК-нь 2025 оны 07 сарын 22-ны өдөр биелэлтийг нотлох баримтын хамт, 24 нэгжийн 2025 оны 10 сарын 24-ны өдрийн байдлаарх биелэлтийг 2025 оны 10 сарын 28-ны өдөр Үндэсний аудитын газарт, Хууль зүй, дотоод хэргийн яаманд төвлөрүүлэн захирагч буюу төсвийн 22 нэгжийн болон төрийн өмчит байгууллагын 2025 оны 08 сарын 30-ны өдрийн байдлаарх билэлтийг 2025 оны 09 сарын 05-ны өдрийн 1/10446 дугаар албан бичгээр, нотлох баримтын хамт тус тус хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэн биелэлтийг нотлох баримтын хамт хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавих, төрийн аудитын цахим сан fas.audit.mn талбарт байршуулахад зөвлөн, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар онцгойлон ажилласан.

Хоёр.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт

Байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр баталсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”-ний дагуу Нийслэл, орон нутгийн хэлтсүүдэд чиглэлийн нэгжүүдийг хамарсан иж бүрэн хяналт шалгалт, дотоод аудитыг батласан удирдамжийн дагуу гүйцэтгэж, шалгалтын үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгөх мөн албан тушаалын тодорхойлолтод тусгасан ажил

үүргийг хангалттай биелүүлэн ажиллаагүй албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу сахилга, хариуцлагын арга тооцуулах саналыг хүргүүлэн ажилласан.

Дотоод хяналт шалгалтад хамрагдсан нэгжүүд:

1. Дархан-Уул аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
2. Дорнод аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
3. Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
4. Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
5. Увс аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
6. Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
7. Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
8. Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
9. Баянхонгор аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
10. Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
11. Өвөрхангай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
12. Архангай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
13. Завхан аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
14. Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
15. Багахангай дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
16. Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
17. Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
18. Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс

Гурав. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 сарын 29-ны өдрийн удирдамж, Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” зорилтын 1.2.15 дахь арга хэмжээний байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах заалтыг хангах хүрээнд 2025 оны эхний 8 сарын цалин хөлс олголтод хууль, тогтоомжийн хяналт-шинжилгээ хийхээр 2025 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал ажлын 15 өдөрт багтаан хийж гүйцэтгэлээ.

Одоогийн хэрэгжиж байгаа хууль, дүрэм, журам, цалин хөлс, нэмэгдлийг хуулийн хүрээнд тогтоосон талаар болон цаашид хэрэгжүүлэх асуудалд зөвлөмж өгч хяналт-шинжилгээ хийж ажиллалаа.

Засгийн газрын 2025 оны 196 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор Нийслэлийн Улсын бүртгэлийн газар татан буугдсантай холбоотойгоор нийслэлийн 9 дүүргийн 420 албан хаагчийн цалинг 2025 оны 08 сараас эхлэн ерөнхий газарт “Төрийн албаны цалингийн систем” болон “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-д оруулан ажилласан байна.

2025 оны төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв шинээр болон ахиулан олгохдоо даргын 2025 оны 08 сарын 01-нээс хэрэгжүүлэхээр Б/456 дугаар тушаалаар Ерөнхий газрын 25 албан хаагч, Б/457 дугаар тушаалаар дүүргийн бүртгэлийн хэлтсийн 142 албан хаагч, Б/457 дугаар тушаалаар аймгийн Улсын

бүртгэлийн хэлтсийн 250 албан хаагч, нийт 417 албан хаагчийн цалинг нэмэгдүүлсэн байна.

Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв олгох болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд анхаарал татсан зөрчил илрээгүй, бүх албан хаагчид төрийн албаны хуульд заасан нэмэгдлээ авч байна.

Засгийн газрын 2023 оны 213 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албанд ажиллах мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”-ээр Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн програмист Ч. Дэлгэрбаяр, С.Дэлгэрмөрөн, Д.Ууганбаяр, уг газрын мэдээллийн сүлжээ, техникийн хэлтсийн ажилтан А.Лхагвасүрэн нар цалинжиж байна.

Уг итгэлцүүрээр тогтоосон орон тооны дээд хязгаарын хүрээнд байгууллагын албан хаагчийн ямар өндөр ур чадварыг харгалзан тогтоосон нь тодорхойгүй байна.

2025 оны зэрэг дэвийн нэмэгдлийг энэ оны 08 сараас олгохоор тушаал гарч байгаа нь Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.10 -т зааснаар “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл хөлсийг тухайн албан хаагчийн албан тушаалын цалингаас доор дурдсан хувиар тооцож, сар тутам олгоно”, үнэлгээний багийн үнэлсний дараагийн сараас эхлэн нэмэгдүүлэхгүй зэрэг дэвийн нэмэгдлийг 6 сараар дутагдуулан олгосон байна.

Энэ нь нэг албан хаагчдад дунджаар 430,0-508,0 мянган төгрөг буюу нийт цалингийн зардлыг 150,4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

“Төрийн албаны цалингийн систем” болон “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-ийн уялдаа холбоог нягтлахад албан тушаалын нэршил, үндсэн цалингийн хэмжээ зөрүүтэй зэрэг алдаа, дутагдал ирүүлснийг холбогдох нэгж, албан хаагчдад хүргүүлэн засварлуулсан.

Дөрөв.Худалдан авах ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 сарын 18-ны өдрийн удирдамж, Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх” зорилтын 1.3.6 дах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны худалдан авах ажиллагаанд хууль, тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх, түүний явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийг дуустал ажлын 7 өдөрт багтаан хийж гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй бөгөөд зөвхөн урсгал төсвийн хүрээнд Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны 01 сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан тус газрын худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 31 дүгээр зүйлийг баримтлан нээлттэй тендер шалгаруулалт 8,

харьцуулалтын худалдан авалт 1, шууд худалдан авалт 7, нууцаар 1 арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3, 44.4 дэх заалтыг хэрэгжүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 01 сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалаар 29.205,7 сая төгрөгөөр худалдан авахаар 9 төсөл, арга хэмжээг баталж ирүүлсэн байна.

Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг 2025 оны 04 сарын 03-ны өдрийн 1/4649, 2025 оны 06 сарын 03-ны өдрийн 1/7604 дугаар албан бичгээр нэршил, батлагдсан төсвийн өөрчлөлт болон 8 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэх, 2025 оны 08 сарын 07-ны өдрийн 1/9557 дугаар албан бичгээр худалдан авах аргыг солих өөрчлөлтийн саналыг тус тус хүргүүлсэн.

Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, батлагдсан төсвийн өөрчлөлтийн саналыг хүргүүлсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас худалдан авах шинэчлэгдсэн төлөвлөгөө батлагдаж ирээгүй байна.

Тендер зарласан хугацааг tender.gov.mn цахим системд оруулсан байдлыг нягталж хянахад хугацаа хэтэрсэн зөрчил байхгүй, үнэлгээний хороодууд нь төлөвлөсөн цаг хугацаандаа багтаж худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан, батлагдсан төсөв болон байгуулсан гэрээгээр 194,7 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Гэрээний дагуу нээлттэй болон шууд худалдан авах ажиллагааны хувьд гэрээнд тусгагдсан хугацаандаа төлбөрөө төлөөгүй нээлттэй тендерийн 3.089,6 сая төгрөг, шууд худалдан авалтын тендерт 58,7 сая төгрөг, нийт 3.148,3 сая төгрөгийн өглөгтэй байна.

Гэрээний дагуу худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 917,3 сая төгрөгийн, 21 нэр төрлийн гэрчилгээ, маягт, хавтас хүлээн авсан байна.

Иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэхээр байгуулсан гэрээний дүнд 2025 оны 08 сарын 25-ны байдлаар 162.939 ширхэг, 2.932,1 сая төгрөгийн үнийн дүнтэй иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлсэн байна. Гэвч гэрээгээр 8 сарын 20-ны дотор бүрэн нийлүүлэх хугацаа хэтэрсэн боловч нийлүүлэгч байгууллагаас 2025 оны 08 сарын 15-ны өдрийн 25/030-н дугаар албан бичгээр нийлүүлэх хугацааг сунгах хүсэлтийн дагуу 2025 оны 1/9990 дугаар албан бичгээр 10 сарын 01-ны өдрийг хүртэл хүсэлтийг зөвшөөрсөн хариуг хүргүүлсэн байна.

Тендерийн төлөвлөгөөний 16 төсөл, арга хэмжээний хүрээнд 21 худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримт, тендерийн урилга, үр дүнг буюу 21 гэрээнээс 7 гэрээний 5.539,9 сая төгрөгийн гэрээг байршуулсан.

Оролцогчдоос тодруулга авахаар 2 (Гадаад паспортын бэлдэц, техник, тоног төхөөрөмж тендерийн баримт бичгээс), Ерөнхий газраас 3 (Орон нутгийн УБХ үйлчилгээний авто машин, улсын мэдээллийн маягт нийлүүлэх, бичиг хэргийн материал нийлүүлэх) тендерийн бичиг баримтад нийлүүлэх барааний техникийн тодорхойлолтод нэмэлт тодруулга өгч ажилласан байна.

Сангийн яамнаас ирүүлсэн “Гомдол хянасан тухай” 02/5439 дугаар албан бичигт “Тендер шалгаруулалтын 2 дугаар багцад захиалагчийн ирүүлсэн баримт материалд үндэслэн хянан үзэхэд “Дижитал сервис”ХХК-ийн гаргасан гомдол үндэслэлгүй болохыг дурдсан байна. Тиймээс УБЕГ/20250102008 дугаартай “Бичиг хэргийн материал худалдан авах” 2 дугаар багцад гарсан гомдлын мөрөөр дахин үнэлгээ хийж, “Алтанзуун” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан байна.

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан УБЕГ/20250202017 дугаартай “Улсын бүртгэлийн ерөнхий тог баригчийн батарей худалдан авах тендерт гарсан гомдлын мөрөөр захиалагчийн шийдвэрийг зөв гэж үзсэн тул “Жи Си Эс Эм трейд” ХХК-тай №2025/28 дугаар гэрээ байгуулан ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж батална” гэсэн заалтыг хэрэгжүүлэн тус газрын “мөнгөн гүйлгээний журнал”-ыг шүүж үзэхэд нь 2025 оны худалдан авах ажиллагаанд төлөвлөгөөнд тусаагүй төлбөр шилжээгүй, худалдан авалт хийгээгүй байна.

Даатгалын үйлчилгээ /Эд хөрөнгийн/-ний шууд худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дах хэсгийн зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч худалдан авалтыг зохион байгуулах тул тус яаманд тухайн худалдан авалтыг зохион байгуулах тухай 2025 оны 05 сарын 21-ний өдрийн 1/7096 дугаар албан бичиг хүргүүлсэн боловч өнөөдрийн байдлаар хариу ирээгүй байна.

Орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний авто машин (5-н аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс) худалдан авах УБЕГ/20250102019 дугаар бүхий тендерийн урилгыг 6 дугаар сарын 13-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад байршуулж, 7 дугаар сарын 04-ний өдөр нээсэн боловч шаардлага хангасан тендер ирээгүй шалтгаанаар дахин тендер зарласан, тендерийг 8 дугаар сарын 11-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn, сайт, шилэн самбарт тус тус дахин байршуулж, 9 дугаар сарын 10-ны өдөр нээхээр ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн заалтын дагуу тендер зарласан хугацааг tender.gov.mn цахим системд оруулсан байдлыг нягталж хянахад хугацаа хэтэрсэн зөрчил байхгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.2, 48,3 дах заалтыг хэрэгжүүлэн 7 үнэлгээний хороодууд нь төлөвлөсөн цаг хугацаандаа багтаж худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг баримтлан нийт 17 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны дүнд 194,7 сая төгрөгийг хэмнэн ажилласан байна.

Гэрээний дагуу худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 917,3 сая төгрөгийн, 21 нэр төрлийн гэрчилгээ, маягт, хавтас хүлээн авсан, хяналтын тооллогоор түүвэрчилж тоолсон бөгөөд илэрсэн зөрчил, зөрүү гараагүй.

Оролцогч талууд хоорондоо өрсөлдөж хуулийн үндэслэлгүй гомдол гаргаж байгаа нь байгууллагын ажлыг удаашруулах, дахин үнэлгээ хийлгэдэг нь цаг хугацаа алдагдах, нөөц тасалдах зэргээр сөрөг нөлөөлөлтэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, төлөвлөгөөгүй худалдан авалт хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1.6 дахь хэсгийг хэрэгжүүлэн тус газрын 2025 оны 2 дугаар улирлын дотоод аудитын тайланг 07 сарын 01-ны өдрийн 1/8569, 3 дугаар улирлын дотоод аудитын тайланг 10 сарын 27-ны өдрийн 1/12269 дугаар албан бичгээр тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

~~~oOo~~~